



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2018 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 21

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах  
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.4, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 6.2.1, 6.4.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн нийт 130,679,681.18 (нэг зуун гучин сая зургаан зуун далан есөн мянга зургаан зуун наян нэгэн төгрөг арван найман мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий хавсралтад заасан автомашин, механизмын 3 дахь дуудлагын худалдаанд оролцогч ирээгүй тул акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2. "Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Нямсамбууд дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор үндсэн хөрөнгийг акталж, данснаас хасах, сэлбэгээр худалдах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 1 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТЭСИЙН  
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.НЯМ-ОСОП

Э.ЭРДЭНЭХИШИГ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын  
 2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн  
 №... дугаар тогтоолын хавсралт



**"Цахилгаан дамжуулах үндэсний сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн  
 үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, акталж, сэлбэгээр худалдах автомашин, механизмын жагсаалт**

Д/д	Автомашинны марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Сэлбэгээр ашигласнаас олох орлогын хэмжээ (төгрөг)
1	УАЗ-469 чиргүүл	2007		365,000.00	365,000.00	0	0	30,000.00
2	Аксент, 95-31УБЯ, суудлын, хөдөлгүүр-628292, арал-423885	2006	430122	6,342,387.50	6,342,387.50	0	0	200,000.00
3	Уаз-31512, 58-81 УБЭ, суудлын, хөдөлгүүр-60305071, арал-572708	1996	507737	11,085,209.76	11,085,209.76	0	0	250,000.00
4	Магнус, 50-05УБГ, суудлын, хөдөлгүүр-400165	2001	417945	20,346,541.00	20,346,541.00	0	0	250,000.00
5	Аксент, 73-27УБИ, суудлын, хөдөлгүүр-534135, арал-408369	2007	346596	6,323,545.00	6,323,545.00	0	0	200,000.00
6	Ландкрузер -80, 11-57 УБМ, суудлын, арал-0035405	1993	408544	28,087,444.55	28,087,444.55	0	0	400,000.00
7	Ландкрузер -105, 05-52 УБЗ, суудлын, хөдөлгүүр-0384777, арал-9006029	1999	673282	43,524,589.97	43,524,589.97	0	0	500,000.00

Д/д	Автомашинь марк, улсын дугаар, зориулалт, хөдөлгүүр, арлын дугаар	Ашиглалтад орсон он	Нийт гүйлт /км/	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)	Сэргээн босголтын зардал (төгрөг)	Сэлбэгээр ашигласнаас олох орлогын хэмжээ (төгрөг)
8	Ниссан бльюверд, 67-37 ОРА, суудлын, 1830, IU14054306	1997	435000	5,170,000.00	5,170,000.00	0	0	200,000.00
9	Соната-3, 15-51 УБЯ, суудлын, 317324, ТМНТF21FPVU868921	1997	447332	9,434,963.40	9,434,963.40	0	0	200,000.00
	<b>Нийт дүн</b>			<b>130,679,681.18</b> (нэг зуун гучин сая зургаан зуун далан есөн мянга зургаан зуун наян нэгэн төгрөг арван найман мөнгө)	<b>130,679,681.18</b> (нэг зуун гучин сая зургаан зуун далан есөн мянга зургаан зуун наян нэгэн төгрөг арван найман мөнгө)	-	-	<b>2,530,000.00</b> (хоёр сая таван зуун гучин мянган)